

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№21/540

ШУС, НУС

2020

МОНГОЛ, ХЯТАДЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА
(“Хөдөлмөр” сонины жишээн дээр)

Д.Цэнд*

*СУИС-ийн Радио телевиз, медиа урлагийн сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш

Түлхүүр үг: харилцааны үе, найрамдалт харилцаа, хөдөлмөр сонин, эерэг, сөрөг мэдээлэл

Эртний түүхт Монгол, Хятад хоёр улс нь 4709,6 км шугамаар хиллэн, туурга тусгаар оршин, хэдэн мянган жилийн тэртээгээс эдийн засаг, соёлын харилцааг хөгжүүлж ирсэн түүхэн уламжлалтай юм.

“Монгол Улс төр улсаа байгуулснаас хойш бичигдсэн түүх нь 2200 жил бол хятад үндэстэн эртний Шан Инь (商殷) үеэс өнөө хүртэл бичигдсэн 3500 жилийн түүхтэй ард түмэн. Манай хоёр улсын ард түмэн Хан хийгээд Хүн улсын үед түүхэн хилээ тогтоож, тэр нь Хятадын цагаан хэрмээр зааглагдан харилцаж ирсэн бөгөөд МЭӨ 198 онд энх ургийн гэрээ байгуулж, цагаан хэрмээс урагш нутаглагчид нь Хань улсын иргэд, цагаан хэрмийн хойгуур нутаглагч “нум сум агсаж, морь унасан иргэд” нь Хүн улсын иргэд хэмээн 2100 жилийн тэртээ хоёр улсын харилцааг бататгасан гэрээ байгуулж байсан түүхтэй”¹ хэмээн судлаачид тэмдэглэжээ.

Эрт үеэс эдүгээг хүртэлх он жилүүдэд хоёр улсын харилцаа эрээн бараантай, ээдрээтэй замыг туулж

ирсэн байдаг. 1949 оны 10 дугаар сарын 16-нд БНМАУ, БНХАУ-тай дипломат харилцаа тогтоосноор Монгол, Хятадын харилцааны шинэ үе эхэлсэн. Энэ үеэс хойших хоёр улсын харилцааг түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D) Ж.Баясах гурван үе шат болгон хувааж үзсэнийг иш үндэс болгон, хэвлэл мэдээллийн харилцааг ч мөн энэ үе шатуудад хуваан үзэж болно. Үүнд:

- Нэгдүгээр үе 1949-1966
- Хоёрдугаар үе 1966-1985
- Гуравдугаар үе 1989-оноос эдүгээ хүртэл² гэж үзжээ.


Дээрх үе шатуудыг үндэслэл болгон Монголын Үйлдвэрчний Эвлэлийн “Хөдөлмөр” сонины тодорхой дугааруудад ажиглалт хийв. 91 жилийн түүхтэй тус сонин нь Монгол Улсын ажилчин ангийн эрх ашгийг хамгаалсан хэвлэл төдийгүй 1950-1960-аад оны үед БНМАУ-д ажиллаж байсан хятад ажилчдын эрх ашгийг хамгаалахад ч нийтлэлийн бодлогоо чиглүүлж байсан юм. Тухайн үедээ БНМАУ-ын тэргүүлэх сонинуудын нэг байсан тус сонин нь олон мянган уншигч, захиалагчтай (1989 онд 135.000 хувь хэвлэгдсэн) долоо хоногт гурван дугаар хэвлэгдэж байжээ.

“Хөдөлмөр” сонины 1959, 1969, 1979, 1989 оны дугааруудад БНХАУ-ын

талаар нийтлэгдсэн материалд агуул-
гын судалгааг хийж үзэв.

| Он | Хэвлэсэн материал | Эх бичвэр | Эх бичвэрийн ерөнхий агуулга болон үг хэллэг | Хэвлэсэн дугаар | Эх сурвалж |
|-------------|-------------------|----------------------------------|--|-----------------|---|
| 1959 | 10 | Эерэг | Хятадын түүх дурсгал, төмөр зам, ард түмний соёлч байдал | 156 | Сонин өөрийн эх сурвалжаас |
| 1969 | 7 | Сөрөг | Өдөөн хатгалга, хилэгнэн эсэргүүцэж байна. заналхийлэл | 144 | Дам эх сурвалж (МОНЦАМЭ, Дели, Москва) |
| 1979 | 30 | Сөрөг | Хорлон сүйтгэл, хилэгнэн эсэргүүцэж байна, зэмлэн буруушаах, өдөөн хатгалга, их ухралт | 144 | Дам эх сурвалж (МОНЦАМЭ, Дели, Москва) |
| 1989 | 9 | Эерэг | Өмнө зүгийн хөрш орон, хятад орноор аялсан нь, хятадын дурсгалт газрууд, дугуй | 144 | Сонины өөрийн эх сурвалж |
| Нийт | 56 | Эерэг - 19 Сөрөг - 37 | | 588 | |

Хүснэгт №1. “Хөдөлмөр” сонины эх бичвэрийн тойм



Зураг 1. “Хөдөлмөр” сонинд БНХАУ-ын тухай хэвлэгдсэн мэдээллийн тоо (1959-1989 онд)

Хоорондоо арван жилийн зайтай, 30 жилийн хугацаад тус сонинд БНХАУ-тай холбоотой нийт 56 материал нийтлэгдсэн бөгөөд эдгээрийн 34 хувь нь эерэг, 66 хувь нь сөрөг мэдээлэл байгаа юм. 1979 онд хамгийн олон сөрөг мэдээлэл хэвлэгдсэн байгаа нь тухайн үед дэлхийн улс орнууд хоёр том лагерьт хуваагдсан, хүйтэн дайны талаар хамгийн их мэдээлж байсан,

олон улсын байдал түгшүүртэй жилүүдэд хэвлэгдсэн байна.

Нэгдүгээр үе 1949-1966 он. Дипломат харилцаа тогтоосноос хойш 10 гаруй жилд хоёр орны нийгэм, улс төр, эдийн засгийн харилцаа идэвхтэй өрнөж, 1951 онд худалдааны хэлэлцээр хийж, 1952 онд боловсролын байгууллагууд хооронд харилцаа тогтоож, 1958 оноос хоёр улсын мэдээллийн хамгийн том агентлагууд болох Синьхуа (新华), МОНЦАМЭ хамтран ажиллаж эхэлсэн байдаг. Энэ үед нийгэм, улс төрийн бодлогоо дагаад хоёр орны хэвлэл мэдээллийнхэн ч дотно харилцаж мэдээлэл солилцож байжээ.

1961 онд Хятад-Монголын найрамдлын өдрүүдэд Монголын урлаг, соёл, хэвлэл мэдээллийнхэн оролцсон бол мөн онд БНМАУ-ын ардын армийн 40 жилийн ойд БНХАУ-ын БХЯ-ны нэгдүгээр орлогч, армийн генерал Сюй Гуан-да (徐冠达) оролцсон байна. “Генералын зургийг олох үүрэг тус “Улаан Од” сонины эрхлэгч Ж. Ядмаад оногд-

сон бөгөөд Хятадын Элчин сайдын яамны Синьхуа хорооны төлөөлөгч, Гадаад Явдлын Яам, Батлан Хамгаалах Яам зэрэг газруудтай холбогдсон ч олноогүй байна. Ж.Ядмаа эрхлэгч Хятадын цэргийн сонины эрхлэгч генерал Ху-ран (胡然) руу утасдаж, генерал ч тусгай онгоцоор сайдын зураг намтрыг илгээж, Ж.Ядмаа эрхлэгч тэрхүү онгоцыг Улаанбаатарт саадгүй буух зөвшөөрлийг яаралтай зохицуулснаар тус сонины баярын дугаарт зочны зураг намтрыг хэвлэж амжсан³ байна. Ийнхүү генералын зураг, намтрыг БНХАУ-ын Цэргийн ба Нийгмийг Аюулаас Хамгаалах Хэргийг Эрхлэх Яамны хэвлэл “Улаан од” сонинд хэвлэж байжээ Тус сонин Монгол Улсын Батлан Хамгаалах Яамны архивд хадгалагдаж байна.



Зураг 2. БНХАУ-ын БХЯ-ны нэгдүгээр орлогч, армийн генерал Сюй Гуан-да. “Улаан Од” сонин 1961.03.15.

Энэ үед Монголын хэвлэлүүдэд болон “Хөдөлмөр” сонинд БНХАУ-ын ард түмний нийгмийн амьдрал, ажил үйлс, бүтээн байгуулалт соёл, хөгжил дэвшил, шинжлэх ухааны ололтын тухай мөн Монголд ажиллаж байгаа Хятад ажилчдын мэдээ, сурвалжилга, өгүүлэл, нийтлэл олноор хэвлэгдэж байжээ.

Жишээ нь, 1959 оны “Хөдөлмөр” сонинд “Хятадын ард түмний соёлч байдлаас”, “Хятад ажилчдын хувь нэмэр”, “Хятадын гайхамшигт дурсгалт

зүйлээс” зэрэг өгүүлүүд нийтлэгдсэн байна. “Хятадын гайхамшигт дурсгалт зүйлээс” өгүүлэлд “Дэлхийн хамгийн том хэвлэл бол эртний Хятадын “Юнлэдадянь” (永徽律疏) хэмээх нэвтэрхий толь бичиг ажээ. Энэ толь бичиг нийтдээ 22937 боть номоос бүтсэн байна. ... Эртний дэлхий дахины урлаг утга зохиол, түүх газар зүйн шинэ нээлт Сун-Юань (宋元) улсын хөгжилтийг нэвт тольдсон энэ үнэт бүтээл дэлхийд ховор эрдэнэ ажээ⁴ хэмээн Хятадын төдийгүй дэлхийд хосгүй үнэт бүтээлийн талаар мэдээлэл өгсөн, ач холбогдолтой өгүүлэл нийтлэгдсэн байдаг.

Мөн оны аравдугаар сарын дугаарт төр нийгмийн зүтгэлтэн зохиолч, сэтгүүлч С.Удвал “БНХАУ-ын эмэгтэйчүүд” өгүүлэлдээ Хятадын Бүгд Найрамдах Улсын анхны удирдагч Сун Ятсений (孙中山) эхнэр Сун Цзин-Линий (宋庆龄) талаар бичихдээ “Сун Цзин-Лин 1921 онд Сун-Ятсений үнэнч хань, дотно нөхөр болж империализмын эсрэг ард түмний өргөн тэмцэлд оролцохын хамт, Хятадын хувьсгалт хүчийг зөвлөлт ба дэлхий дахины ажилчны хөдөлгөөнтэй холбох бодлогыг баримталж иржээ. Сун Цзин-Лин Хятадын ард түмний чөлөөлөх дайны хамгийн хүнд жилүүдэд ч гэсэн ард түмний хүчинд бат итгэж, түрэмгийлэгчдийн эсрэг зоригтой тэмцэж байжээ. 1949 онд Сун Цзин-Лин нь БНХАУ-ын Ардын төв засгийн газрын даргын зургаан орлогчийн нэгэнд сонгогджээ⁵ гэж өгүүлсэн байна.

Жил бүр Монгол, Хятадын найрамдлын арав хоногийн өдрүүд болж, Хятадын ард түмний уламжлал, соёл, тэргүүн туршлагыг сурталчлан таниулж байжээ. Мөн эдийн засгийн

тусламж, техник технологийн хөгжил, эмнэлгийн шинжлэх ухааны ололттой талууд, Хятадын ард түмний бие бялдрын талаар мэдээлэхийн зэрэгцээ Монголын Үйлдвэрчний Эвлэл, залуучуудын болон урлагийн байгууллагуудын хамтын ажиллагааны тухай мэдээ мэдээлэл давамгайлж нийтлэгдсэн байна. Эдгээр мэдээллийг Монголын төр нийгмийн зүтгэлтэн зохиолч С.Удвал, Э.Оюун, сэтгүүлч Р.Цэвэгмид, Ч.Лувсанжав нар бичиж байсан нь хоёр орны найрамдалт харилцаа хамтын ажиллагаанд ихээхэн ач холбогдол өгч байсныг илтгэн харуулж байгаа юм.

Хоёрдугаар үе 1966-1985 он. 1966-1985 онуудад ЗСБНХУ, БНХАУ-ын хооронд дайн ба энхийн асуудал, гадаад дотоод чиг шугамын талаар зөрөлдөж, хоёр орны харилцаанд огцом өөрчлөлт гарч эхэлсэн үеэс БНМАУ, БНХАУ-ын харилцаа ч зогсонги байдалд орсон байдаг. Энэхүү харилцаа нь хоёр орны хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагааг тойрч өнгөрөөгүй бөгөөд мэдээллийг Москва, Дели гэх мэт дам эх сурвалжаас авсан БНХАУ-ын бодлого үйл ажиллагааг илт буруутган, шүүмжилсэн нийтлэлүүд зонхилж байлаа.

Энэ үед хэвлэгдсэн нийтлэлээс дурдвал “Их үсрэлт биш их ухралтын жилүүд”, “Хятадын удирдагчдын балмад ил шугам”, “Өнөөгийн Хятадын хөдөлмөрчдийн байдал”, “Бээжин өдөөн хатгасаар байна”, “Бээжингийн хорлон сүйтгэх ажиллагаа” гэх мэт сөрөг, зэмлэсэн, буруутгасан мэдээлэл зонхилж байна. Тодруулбал, “Хөдөлмөр” сонины 1959 оны №78 дугаарт “Хятадын хөдөлмөрчдийн аж амьдрал” өгүүлэлд “Хятад улсад аж үйлдвэрийн бараа, хүнсний гол бүтээгдэхүүний хуваарилалтад картын систем тогтоосон хэвээр байна. Хотод сард

хүнд ажлын нэг ажилчинд 17-20 кг, хөнгөн ажлын нэг ажилчинд 14 кг, хөдөлмөрийн чадваргүй хүнд 11 кг үр тариа хуваарилж байгаа нь 1955 онд БНХАУ-ын төрийн зөвлөлийн тогтоосон нормоос 14-18 хувиар бага байна⁶” гэсэн мэдээлэл бичсэн байна. Мэдээллийн харилцаа тасарсан ч дам эх сурвалжаас авсан сөрөг мэдээллүүд нийтлэгдсээр байжээ. Энэ нь хоёр орны харилцаа гаднын хүчин зүйлээс ихээхэн хамааралтай байсныг илтгэн харуулж байгаа юм.

Гуравдугаар үе буюу 1989 оноос эдүгээ хүртэл. Хоёр орны нийгэм, улс төр, эдийн засгийн төдийгүй мэдээллийн харилцаа ч тасраад, 1980-аад оны сүүл 1990-ээд оноос дахин сэргэж эхэлжээ. 1980-аад оны сүүл үеэс БНМАУ-д гарсан ардчилал, өөрчлөлт шинэчлэлт нь Монгол орны нийгэм, эдийн засаг, эрх зүйн орчныг үндсээр нь өөрчилсний дотор хэвлэл мэдээллийн салбарт ч том хувьсал болсон юм. 1990 онд БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн дарга П.Очирбат БНХАУ-д, 1991 онд БНХАУ-ын дарга Ян Шанхунь (杨山洪) БНМАУ-д албан ёсны найрсаг айлчлал хийснээр хоёр улсын харилцаа шинэ эрин үед шилжиж, бүхий л салбарт хамтран ажиллаж эхэлсэн юм.

Энэ үеэс хоёр орны хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бодитой хамтран ажиллаж, мэдээ, мэдээлэл, мэргэжилтэн солилцдог болов. Энэ үеийн “Хөдөлмөр” сонинд хэвлэгдсэн БНХАУ-ын тухай мэдээллээс дурдвал “Дугуйнаас үүдсэн бодлын хэлхээ”, “Хятад орноор аялж, Монгол орноо бодсон минь”, “Өмнө зүгийн их хөрш орноор”, “Бээжин хотын дурсгалт газрууд”, “Манай хоёр орныг нийлэг үйлс, зорилго нэгтгэдэг”, “Чингисийн дүрийг бүтээсэн анхны Монгол хүн” гэх мэт эерэг

мэдээллүүд нийтлэгдэж эхэлсэн байдаг. “Хятад орноор аялж, монгол орноо бодсон минь” өгүүлэлд “Хятад улс тэрбум нэг зуун сая хүнээ хооллож, хувцаслаж бүрэн чадаж байна. Үйлдвэрлэл хэрэглээ, зохион байгуулалтын үлгэр дуурайл гэж чухамхүү үүнийг л хэлэх байх... Хятадын эмэгтэйчүүдийн нуруун дээрх ачаа хөнгөн гэж хэлж болох мэт санагддаг. Дийлэнх олонх нь төлөвлөгөөтэй төрөх хуулийн дагуу ганц хүүхэд төрүүлнэ. Гэрт хоол ундыг нь голдуу эрчүүд хийнэ. Хүнд хүчир ажилд эмэгтэйчүүд ажиллах нь ховор”⁷ хэмээн бичжээ. “Хөдөлмөр” сонины дээрх өгүүллүүдийг С.Рэнчин,



Э.Сонинтогос, Ц.Ганболд, Д.Лүнгэринчин, Д.Садив нарын сэтгүүлчид бичиж байсан байна.

*Зураг 3. “Дугуйнаас үүдсэн бодлын хэлхээ”.
“Хөдөлмөр” сонин 1989 он.*

1991 оноос “Үнэн”, “Улаан од”, “Хөдөлмөр” сонинууд өөр өөрийн чиглэлийн сонинтой, нийслэлийн “Улаанбаатар” сонин “Хөх хотын өдрийн сонин”-той, 1993 оноос “Монголын радио”, Хятадын олон улсын радиотой хамтран ажиллаж мэргэжилтэн солилцож эхэлснээр хоёр орны хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагааны шинэ эрин үе эхэлсэн.

Монголын хэвлэл мэдээллийн салбарынхан Бүх Хятадын сэтгүүлчдийн холбоо, ӨМӨЗО-ны Ардын Засгийн газрын хэвлэл мэдээллийн алба зэрэг байгууллагууд хамтран ажиллаж

тодорхой үр дүнд хүрсэн байна. 2010 оноос эхлэн Монгол, Хятадын хэвлэл мэдээллийн форумыг хийхээр хоёр орны мэргэжлийн байгууллагуудын хооронд гэрээ байгуулж, энэ онд арав дахь удаагийн форумыг хийлээ.

2013 оны аравдугаар сард Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Кэцян (李克强 л) нар Бээжин хотноо гарын үсэг зурсан “Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр”-ийн дөрөвдүгээрт буюу “Хэвлэл мэдээллийн байгууллагуудын солилцоо” хэсэгт “Талууд Монгол, Хятадын хэвлэл мэдээллийн форумыг жил бүр ээлжлэн зохион байгуулна”⁸ гэж зааснаар хэвлэл мэдээллийн байгууллагуудын хооронд хийгдэж байсан ажил хоёр орны Засгийн газрын бодлогод тусгалаа олсон юм.

Хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах талаар төрөөс баримталж буй бодлогын дараагийн чухал баримт бичиг нь Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, БНХАУ-ын дарга Си Зиньпин (习近平) нар Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан “Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэл, харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал” юм.

Тунхаглалд “Талууд цаашид хоёр улсын хэвлэл мэдээллийн харилцан солилцоог улам идэвхжүүлж, зөвлөлдөх уулзалт, форум зэрэг хамтын ажиллагааны механизмыг ашиглан кино, телевизийн нэвтрүүлэг хийх, дамжуулан нэвтрүүлэх, харилцан солилцоог хөгжүүлэхэд таатай нөхцөлийг бүрдүүлнэ”⁹ гэж заасан нь хоёр орны хэвлэл

мэдээллийн салбарын хамтын ажиллагааг төр засгийн дээд түвшинд дэмжсэн шийдвэр юм. Төр засгийн түвшний эдгээр шийдвэр нь хоёр орны хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжин, боломж олгож байгаагаараа онцлог юм.

Дүгнэлт: Олон зуун жилийн харилцаатай Монгол, Хятад улс өдгөө харилцаагаа шинэ түвшинд гаргаж чадсан нь хэвлэл мэдээллийн байгууллагуудад төдийгүй мэдээллийг үнэн бодитоор хүлээн авах эрх Монголын ард түмэнд бий болсон явдал юм. Харилцаа муудаж байсан үе нь гадаад хүчин зүйлээс хамааралтай байв.

Хоёр орны нийгэм, эдийн засгийн харилцаа шинэ түвшинд гарснаар хэвлэл мэдээллийн байгууллагынхны харилцаа, хамтын ажиллагаа ч өндөр түвшинд хүрлээ.

Цаашид хоёр орны тухай, хэвлэлд нийтлэгдсэн материалыг үечлэн, нарийвчилж судлах шаардлагатай гэж үзэж байна.

Эшлэл

- 1 Баясах Ж. 2009. Монгол Хятадын улс төрийн харилцаа 60 жилд. // Олон улсын бага хуралд тавьсан илтгэл.
- 2 Баясах Ж. 2010. Гадаад бодлого хийгээд аюулгүй байдал. УБ., х.34.
- 3 Галаарид Б. Монгол, Хятадын хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагааны өнөөгийн байдал. эрчимжүүлэх арга зам, боломж. “Сэтгүүл зүй” 2014.
- 4 Хятадын гайхамшигт дурсгалт зүйлээс. “Хөдөлмөр” сонин. 1959.10.6. №112.
- 5 Удвал С. БНХАУ-ын эмэгтэйчүүд. “Хөдөлмөр” сонин. 1959.10.28. №89.

- 6 Хятадын хөдөлмөрчдийн аж амьдрал. “Хөдөлмөр” сонин 1979.6.5. №62.
- 7 Хятад орноор аялж Монгол орноо бодсон минь. “Хөдөлмөр” сонин. 1989.9.7 №99.
- 8 www.president.mn. Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр”
- 9 www.president.mn “Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэл, харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал”

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Батжаргал Д. Дүрслэл. УБ., 2014.
2. Баясах Ж. Гадаад бодлого хийгээд аюулгүй байдал. УБ., 2010.
3. Норовсүрэн Л. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. 1-р боть. УБ., 2000.
4. “Хөдөлмөр” сонин 1959, 1969, 1979, 1989 оны дугаарууд
5. МУИС-ийн ЭШБ “Сэтгүүл зүй” сэтгүүл
6. www.president.mn

Summary

Mongolian and Chinese media cooperation is a topic for specific research. We should study and review the media organizations operations of the two countries in periods when the ideology atmosphere is not friendly and the changes after positive relations in last years. It is not possible that we focus on wide range issues in an article. That is why this article reflects on interruption of media organizations cooperation due to ideological difference and cooperation restoration in recent times.